

Орос-Монголын хил орчмын иргэдээс авсан ярилцлага судалгааны дүнгээс

Based on the results of interviews conducted with residents of the Russian-Mongolian border area

Дашдоржийн Оюунгэрэл¹

Доктор (Ph.D), дэд профессор
МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн
НУС-ын Философи, шашин судлалын
тэнхимийн ахлах багш
oyungerelnum@gmail.com

Oyungerel Dashdorj

Doctor (Ph.D), associated professor
Lecturer, Department of Philosophy &
Religious Studies, School of Social Sciences,
National University of Mongolia
oyungerelnum@gmail.com

Хураангуй

XIX – XXI зууны эхэн үеийн баруун-өмнөд Сибирь болон Монголын хил дамнасан газар нутаг дахь шашин шүтлэгийн төлөв байдлын түүхэн нөхцөл байдлыг угсаатан-соёлын үйл явц ба төрийн бодлогыг хэрэгжүүлсэн туршилагын хүрээнд судлахад чиглэж буй төслийн хүрээнд уг илтгэлийг бэлтгэсэн бөгөөд хоёр орны хил орчмын иргэдээс тодорхой санал асуулгыг авч дүгнэлт хийсэн болно.

Ярилцлага судалгааны үр дүнд хил орчмын иргэдийн амьдрал ахуйн нөхцөл байдал, тулгарч байгаа асуудал ба шашин шүтлэгийн харилцан хамаарлыг нийгэм-эдийн засаг, улс төрийн үйл явцын хүрээнд хэрхэн явагдаж байгааг гаргахыг зорилоо.

Түлхүүр үг: шашин шүтлэг, соёл, үндэстэн, үндэстний онцлог, хил хязгаар

Abstract

The report was prepared as part of a project aimed at studying the historical situation of religion in the cross-border areas of southwestern Siberia and Mongolia at the beginning of the 19th - 21st centuries in the context of ethno-cultural processes and the experience of implementing state policies. conclusions are made based on the survey.

As a result of the interview research, we aimed to find out how the life and household conditions of the people near the border, the problems they face, and the interrelationship of religion in the framework of socio-economic and political processes.

Keywords: religious, culture, nation, national identity, boundaries

I. Оршил

Өмнөд ба баруун Сибирь, мөн Монголын тодорхой бүс нь түүх соёлын өвөрмөц газар нутаг мөн бөгөөд түүний тод жишээ нь угсаатан ба шашны олон янз байдал юм. Ингэхдээ тухайн газар нутагт оршин суудаг үндсэн угсаатнууд

¹© Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

(Монгол, Орос, Алтайчууд, Казакууд, Тувачууд, Татарууд) XIX-XXI зууны эх хүртэлх хугацаанд ямагт олон соёлын харилцан үйлчлэлд байж, хил дамнасан газар нутгийн шашны нөхцөл байдалд зайлшгүй нөлөөлж иржээ. Оростой хиллэдэг онцлог нь дараах хэд хэдэн нөхцөл шалтгаанаар тайлбарлагдана. Үүнд:

- Зарим орон нутгийн иргэдийн хувьд төвөөс алслагдсан, үйлчилгээний хүргээмж сул
- Тэнгэр шүтлэг, ислам, буддын шашин зэрэг шашин шүтлэгийн олон янз байдал зэрэг болно.

Юуны өмнө энэхүү өгүүлэлд ОХУ-тай хиллэдэг Монгол Улсын аймаг, сумдын мэдээллийг хүргэж байна.

№	Аймаг	Сум	Хүн амын тоо*	Үндэстэн, ястан**	Сүм хийдийн тоо*** (аймгийн хэмжээнд)
1	Баян-Өлгий	Ногоон-Нуур	8371	Казак Дөрвөд Урианхай	25 (Будда-1, Ислам-24)
		Цэнгэл	9846	Казак Тува	
2	Увс	Давст (хандгайт баг)	1594 (445)	Дөрвөд	9 (Будда-6, Христ-2, Ислам-1)
		Тэс	5165	Баяд	
3	Завхан	Тэс (Нисэг баг)	2943 (671)	Халх	6 (Будда-6)
4	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ (Хатгал тосгон)	6988 (3666)	Халх Дархад Хотгойд Урианхай Буриад Сартуул Цаатан	11 (Будда-6, Христ-4)
5	Булган	Тэшиг	3626	Халх Буриад	8 (Будда-4, Христ-4)
		Сэлэнгэ	3290	Халх	
6	Сэлэнгэ	Алтанбулаг	4835	Халх	16 (Будда-4, Христ-12)
		Сүхбаатар	22680	Халх	
7	Хэнтий	Биндэр	4100	Буриад Эзэн	3 (Будда- 3)
		Дадал	3186	Буриад Шаргалууд Сартуул	
		Өмнөдэлгэр	5895	Буриад	

				Гучид	
		Бат-Ширээт	2393	Буриад Халх	
8	Дорнод	Баян-Уул (Өвөр эрэн баг)	4736 (518)	Халх Буриад	2 (Будда- 2)
		Чулуун- Хороот	1875	Халх Буриад	
Тайлбар:					
*Сумдын хүн амын тоо: Статистикийн Үндэсний хорооны 2021 оны 2 сарын мэдээ					
**Үндэстэн ястны мэдээлэл: https://mn.wikipedia.org/					
***Сүм хийдийн тоо. Статистикийн Үндэсний хорооны 2020 оны мэдээ					

Дээрх мэдээлэлд нийт сүсэгтний тоо ороогүй байгаа учир нийт хүн амын хэчнээн хувь нь уг шашныг шүтэж байгаа нь тодорхойгүй байгаа юм. Судлаачдын ажигласнаар “христ болон исламын сүм хийдэд гол төлөв тогтмол ирдэг сүсэгтнүүд давамгайлдаг бол Буддын сүм хийдэд өдөр тутам ирж байгаа сүсэгтнүүд давтагдах нь ховор, ямагт өөр өөр хүмүүс солигдож ирдэг онцлогтой. Иймээс сүм хийдэд өдөр тутам ирж байгаа сүсэгтний тоогоор нийт сүсэгтний тоог гаргах боломжгүй юм. Энэ нь хүн амын дунд социологийн анкетын судалгаа явуулах зайлшгүй шаардлагыг төрүүлдэг”[1] гэдгийг мөн давхар баталж байгаа болно. 1990-ээд оноос өмнө ийм судалгаа улсын хэмжээнд 5 жил тутам явагддаг байсан бол 1990 оноос хойш улсаас зохион байгуулахаа зогссонтой холбоотойгоор судлаачид 10 жилд нэг удаа давтаж хийхийг зорьж байгаа ч тэр бүр хангалттай болж чадахгүй байна.

Монгол Улсын хилийн урт нь 8000 гаруй км урт боловч ОХУ болон БНХАУ гэсэн хоёр л хөрштэй. Монгол Улс нь хойт хөрш буюу ОХУ-тай 1921 оны 11 дүгээр сараас дипломат харилцаатай явж ирсэн түүхтэй. ОХУ нь ерөнхийдөө загалмайтны шашинтай ч бусад олон зүйлийн шашин соёл зэрэгцэн оршиж үйл ажиллагаа явуулдаг байна.


Харьцуулалт	Монгол Улс	ОХУ
Хүн ам	3.4 сая	143 сая
Шашны талаарх бодлого, хууль эрх зүйн баримт	Үндсэн хууль /1992/ Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль /1993/	Сүсэг бишрэлийн эрх чөлөө ба шашны нийгэмлэгийн тухай хууль /1990/, Үндсэн Хууль /1992/, Хэт даврагч үйл ажиллагаатай тэмцэх тухай холбооны хууль /2003/ Ашгийн бус байгууллагын тухай Холбооны хуулийн нэмэлт өөрчлөлт /2006/, Эрүүгийн хуулийн доромжлолын тухай нэмэлт өөрчлөлт /2013/[2]
Үндсэн баримтлал	Аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна.	Аль шашныг төрөөс албадлагаар тогтоож болохгүй.

Шашин шүтэх эрх, эрх чөлөөний заалт	Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй.	Шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сүсэг бишрэлээ мэдэгдэх, хадгалах, түгээх, шашны зан үйл үйлдэх
-------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------

II. Судалгааны арга зүй

ОХУ-тай хиллэдэг Монголын сумдын иргэдийн амьдрал аж ахуй, шашин шүтлэг, нийгэм-соёлын ижил болон ялгаатай талуудыг тандан судлах зорилготой. Судалгааг зорилтот түүврийн аргаар ОХУ-тай хиллэдэг Монголын 8 аймгийн, 16 сумын 80 иргэнийг судалгаанд хамруулсан. Түүврийн зохистой хэмжээг тогтоохдоо сонирхон судалж буй асуудалд бодитой нөлөөлөх хүчин зүйлүүд болох оролцогчдын нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлт зэрэг нийгэм, хүн ам зүйн гол үзүүлэлтийг ашиглав.


Зураг 1. Судалгаанд оролцогчдын насны байдал



Энэхүү судалгааг тоон арга зүйд тулгуурлан урьдчилан бэлдсэн асуумжыг утсан судалгааны аргачлалыг ашиглан авсан.

Судалгаанд хамрагдсан оролцогчдын 44.7 хувь нь эрэгтэйчүүд, 55.3 хувь нь эмэгтэйчүүд байв.

Зураг 2. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин



Ш. Судалгааны үр дүн

Бид судалгаанд оролцогчдоос дараах асуултуудыг буюу (i) хил орчмын нутгийн нэр; (ii) иргэдийн амьдралын үндсэн зорилго, эрхэлдэг аж ахуй зэргийг тодруулахыг зорив.

Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг дээрх хүснэгтээс харж болно.

Хот суурин газраас хэт алслагдсан байдал ажиглагддаг уу? хэмээх асуултад судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь “Орон зайн тэгш бус байдал иргэдийн амьдралд сайнгүй нөлөөлдөг, ялангуяа боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд илүү ажиглагддаг” гэсэн санааг бичжээ.

Мал аж ахуй зонхилон эрхэлдэг бус нутгийн иргэдийн хувьд: ажлын байрны хомсдол, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт их хэмээн хариулжээ. Зарим сумд аймгийн төвөөсөө хэт алслагдсан учраас үйлчилгээний төдийгүй мэдээллийн хомсдолд байдгаа уламжилжээ.

Зураг 3. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин



Газар тариалан сайн хөгжсөн нутгийн иргэдийн хувьд: “Манай нутагт газар тариалан эрчимтэй хөгжиж байгаа. Ажилгүй иргэд ховор, хүн бүр л хашаандаа хэрэгцээний ногоо тарьж, хэрэгцээнээс илүү гарснаа худалдан борлуулах, хотод байгаа хүүхдүүдээ хүнсний ногоогоор хангачихдаг” хэмээн

хариулжээ. Мөн “манайд дэд бүтэц сайн хөгжсөн, төмөр зам болон авто зам сайн хөгжсөн учир алслагдсан гэж боддоггүй” гэжээ.

Мөн аялал жуулчлалын бүс нутагт хамаарагддаг сумдуудыг хөгжүүлэх, гадаад болон дотоодын аялагчдыг татсанаар улс орны нийгэм, соёлын хөгжлийг дэмжих, сурталчлах, эдийн засгийн өсөлт, бүс нутгийн хөгжилд ихээхэн нэмэр болно гэж үзэж байв. Монгол Улсад ирж буй жуулчдын 70 орчим хувь нь байгалийг, 50 орчим хувь нь нүүдлийн соёл, уламжлалт ахуйг, 25 орчим хувь нь Монголын түүх, шашин соёл, Чингис хааны түүхийг сонирхон ирдэг байна. (*Хэнтий аймгийн Дадал, Батиширээт, Өмнөдэлгэр сумдын иргэд; Хөвсгөл аймгийн Хатгал тосгон*)

Хот суурин газраас хэт алслагдсан байдал ажиглагддаг уу?	
Нийтлэг зүйл	Орон зайн тэгш бус байдал иргэдийн амьдралд сайнгүй нөлөөлдөг, ялангуяа боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд илүү ажиглагддаг.
Мал аж ахуй зонхилсон бүс нутаг	Мал аж ахуй зонхилон эрхэлдэг бүс нутгийн иргэдийн хувьд ажлын байрны хомсдол, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт их. Зарим сумд аймгийн төвөөсөө хэт алслагдсан учраас хот хоорондын зам муутай.
Газар тариалан зонхилсон бүс нутаг	Газар тариалан сайн хөгжсөн нутгийн иргэдийн хувьд “Манай нутагт газар тариалан эрчимтэй хөгжиж байгаа. Ажилгүй иргэд ховор, хүн бүр л хашаандаа хэрэгцээний ногоо тарьж, хэрэгцээнээс илүү гарснаа худалдан борлуулах, хотод байгаа хүүхдүүдээ хүнсний ногоогоор хангачихдаг” хэмээн хариулжээ. Мөн “манайд дэд бүтэц сайн хөгжсөн, төмөр зам болон авто зам сайн хөгжсөн учир алслагдсан гэж боддоггүй” гэжээ.

Нэмэлт тайлбар: Нүүдлийн амьдралын хэв шинж зонхилсон, хүн амынх нь нягтрал туйлын бага, газар зүй, орон зайн тэгш бус байдлын улмаас нийгмийн суурь үйлчилгээг хүн амд хүргэхэд нэн бэрхшээлтэй байдал оростой хиллэдэг нэлээд сумдад ажиглагдана. Өргөн уудам нутаг дэвсгэр, байгаль цаг уурын тааламжгүй бүс нутагт тархсан суурьшсан ийм нөхцөлд тэгш бус байдал байна. Алслагдсан бүс нутгийн хүн амд нийгмийн болоод соёлын үйлчилгээг хүргэж үзүүлэхэд зардал их шаардагддаг. Тиймээс сурч боловсрох, орлого олох, жижиг бизнес эрхлэх, мэдээлэл, эрүүл мэнд, соёл, боловсролын үйлчилгээг хүртэх боломжоороо суурин газрын иргэдээс хавьгүй доогуур байна. Иймээс хүн хаана амьдарч буйгаас шалтгаалж тэгш бус байдал буурахгүй хэвээр байдаг. Тиймээс алслагдмал нутгийн иргэдэд соёлын болон нийгмийн үйлчилгээг хүргэхэд идэвхтэй анхаарч ажиллах шаардлагатай байгаа болно.

1990-ээд оноос хойш танай нутагт юу өөрчлөгдсөн бэ? хэмээх асуултад “Мэдээлэл холбоо сүлжээ сайжирсан гэж судалгаанд оролцогчдын ихэнх нь хариулсан бол төвөөс алслагдсан нутгийн иргэдийн хариултад “ажилгүйдэл нэмэгдсэн, хүмүүсийн хот руу чиглэсэн шилжилт ихсэж, нутаг эзгүйрэх хандлага ажиглагдаж байгаа, хүмүүс улам залхуу болсон, уламжлалаа гээж байгаа, уйтгартай болсон” зэрэг хариулт анхаарал татаж байна. Мөн “Хилийн харуул хамгаалалт сайжирсан. Үүнээс улбаалан хил дамнасан малын хулгай


буурч, иргэдийн амьдрал бага болов дээшилсэн, барилга байгууламж нэмэгдэж байна. Ихэнх иргэд бүрэн дунд боловсрол эзэмшдэг болсон, иргэд өөрсдөө хил гарч хэрэгцээтэй зүйлээ олж ирдэг” гэжээ.

Зураг 4. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин



Оросын талд амьдарч буй иргэдтэй юугаараа адил вэ? гэсэн асуултад: Эрхэлдэг аж ахуйн хувьд ижил зүйл ихтэйг оролцогчид онцолжээ. Жишээ нь: мал аж ахуй эрхэлж, цагаан идээ бэлтгэх, нэрмэл, цөцгий, талх барих, хадлан тэжээл бэлтгэх зэрэг, мөн галуу тахиа тэжээдэг, ногоо тарьдаг, эмэгтэйчүүд нь хоолны газар, эрчүүд нь халтуур хийдэг гэсэн хариултууд нийтлэг байна. Увс аймгийн Давст сумын Торхилог багаас судалгаанд оролцогч эрхэлдэг аж ахуй, соёлоороо ижил. Учир нь ОХУ-ын Тува улс нь монгол үндэстэн болох Урианхай ястан түлхүү амьдардаг гэсэн байна.

Зураг 5. Орос, Монголын хил орчмын бүс нутгийн иргэдийн амьдралын ялгаа (зам харгуй, барилга байшин, соёлын тохижилт, нийгэм-эдийн засгийн хангамж зэрэг)



- Амьдралын түвшин: Монгол арай ядуу санагддаг, дэд бүтэц Оросоос сул хөгжсөн, орост бензин, хүнсний бүтээгдэхүүн хямд.
- Нийгэм соёлын орчин: Ялгаатай. Манайд соёлын ажил маш хойрго байдаг хэмэн шүүмжилжээ.
- Худалдаа үйлчилгээний хувьд: Хилээр шууд бараа Алтанбулаг Хиагт шиг орж ирдэггүй, Улаанбаатар хотоос худалдааны барааг татдаг нь том ялгаа
- Техник, технологийн үзүүлэлт биднийхээс хол илүү.

Оросууд төвөөс алслагдсан нутгийн иргэддээ тэтгэвэр, тэтгэмж, хүнсний хангамж сайн үзүүлдэг зэргээр хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан иргэдээс “Танд боломж олдвол Оросын талд очиж амьдрах уу эсхүл Монголдоо амьдарсан нь дээр гэж үздэг үү” хэмээн тодруулан асуухад: судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь “үгүй” хэмээн 88.2 хувь нь хариулжээ. Ийнхүү хариулсан үндэслэлийг нь тодруулахад: “Хэл ус мэдэхгүй, хүний нутагт байснаас төрсөн нутагтаа амьдарсан нь дээр”, “эх нутгаа илүүд үзнэ”, “хангамж сайтай нь сайхан боловч эх орондоо байх нь таатай”, Оросын өвөл их хүйтэн хэмээн гаргажээ. Харин судалгаанд оролцогчдын цөөн хэсэг нь 11.8 хувь нь “тийм” хэмээн хариулсан бөгөөд түүнийхээ үндэслэлийг “Оросын талд очиж амьдарна. Орос, буриад хэл сурна” хэмээн тодруулсан байна.


Зураг 6. Орос, Монгол иргэдийн хооронд нэгдсэн ямар үйл ажиллагаа, нийгэм-соёлын арга хэмжээ явагддаг талаар иргэдийн санаа бодол



Тухайн бүс нутгийн иргэдийн хувьд дээдлэн шүтдэг шашин шүтлэг, зан үйлийг судалгаанд хамрагдсан иргэдээс тодруулсан юм. Ингэхэд дурдсан бүс нутгийн иргэдийн дийлэнх нь *буддын шашин, бөө мөргөл, чоно, байгаль, хангай, эр хүн, уул ус* гэсэн хариултуудыг түгээмэл өгсөн байна. Харин судалгаанд хамрагдсан казах иргэдийн хувьд исламын шашнаа шүтдэг бол, тус бүс нутгийн халх болон урианхайчууд бурханы шашныг шүтэж, нутаг орныхоо

уул овоогоо шүтэн дээдэлдэг талаар онцлон тэмдэглэж байсныг доорх зургаас дэлгэрэнгүй харж болно.

Зураг 7. Дурдсан бүс нутгийн иргэдийн шашин шүтлэгийн байдал



Сүүлийн үед Орос, Монголын хил орчмын бүс нутгийн иргэд тодруулбал, Оросын буриадуудын хувьд буддын шашны нөлөө их байдаг төдийгүй тус улсад шашны өөрчлөлт төдийлэн их харагдахгүй байгаа хэмээн судалгаанд хамрагдсан иргэд хариулсан. Харин Тувачуудын хувьд сүүлийн жилүүдэд христийн шашин шүтэх явдал ихээхэн нэмэгдэх болсныг судалгаанд оролцогчид дурдаж байсныг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй болов уу.

IV. Дүгнэлт

Шашныг судлах нь соёлын судалгааны салшгүй нэгэн хэсэг мөн. Иймээс бид судалгааны объект болгон авч буй газар нутгийн иргэдийн шашин шүтлэгийн онцлог, хөгжлийн түүх, нөхцөл байдлыг судалж тодруулах нь чухал. Үүний тулд нэн тэргүүнд хийх ажил болбоос:

Нэгдүгээрт, Монголын тодорхой бүс нутгийн ард түмний уламжлалт түүхэн дэх угсаатан ба шашны хүчин зүйлийг үндэсний бодлогын хүрээнд, тодорхой шинжлэх ухааны судалгааны арга зүйд тулгуурлан судлах; *хоёрдугаарт*, хүн амын дунд том хэмжээний түүврийн төлөөллийг хамруулсан социологийн судалгаа явуулж, шүтэгчдийн тоо, тэдэнд тулгамдаж буй шашин соёлын асуудлыг тодруулах; *гуравдугаарт*, нутгийн ард иргэдийн дунд соёлын үйл ажиллагааг дэмжих, цаашид шашин соёлын үйл ажиллагааг хэрхэн явуулахыг тодруулсан хэрэгцээ, шаардлыг бодлогын судалгааг явуулах шаардлагатай байна.

Эцэст нь монголын хил хязгаар орчмын угсаатан шашны төлөв байдлыг түүхэн хөгжлийн судалгаа шинжилгээнд тухайн асуудлаар шинэ мэдлэг өгөөд зогсохгүй зөрчилтэй нөхцөл байдлыг урьдчилан харах, түүнийг шийдвэрлэх механизмыг боловсруулах, төрийн байгууллага ба сүм хийд, шашны байгууллагуудын хооронд харилцаа тогтоох хамтран ажиллах хэрэгцээ шаардлага бодит амьдралаас урган гарч байна.

Ашигласан материал

1. Природные условия, история и культура западной Монголии и сопредельных регионов. 2021. Уб., стр. 240
2. Ховд их сургууль. (2020). Монгол Улсын баруун бүс нутаг дахь шашны нөхцөл байдал. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Ховд хот. 94 дэх тал

Бусад эх сурвалж

3. Гантуяа М, Дагвадорж Д, Жамбал А. (2019). Шашин судлал. Уб.,
4. Жамбал А. (2005). Ислам шашин. Уб.,
5. Болормаа О. (2017). Төв Ази дахь христийн шашны түүхийн товч. Уб.,
6. Философийн хүрээлэн, ШУА. (2020). Монгол Улс дахь шинэ шашнууд: Нийгмийн төрх, асуудал, шийдэл. Уб.,
7. Монголын буддын шашны нийгэм хүмүүнлэгийн үйл ажиллагаа. (2018). хянан тохиолдуулсан С.Дэмбэрэл нар. Уб.,
8. Шашны нөхцөл байдлын судалгаа. (2018). Баруун болон төвийн бүсийн зарим аймгийн жишээн дээр. Уб.,
9. Тамир Ч. (2019). Ерээд оны Монголын казах угсаатны эсэргүүцэл: Социологи. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №12 /500/. Уб.,
10. Samuel P. Huntington. (1996). The Clash of Civilizations and the remarking of World Order.
11. Arnold Toynbee. (1960). A Study of History: Abridgement of Vols I–X in One Volume, with new preface by Toynbee & new tables. Oxford Univ. Press
12. Johan Elverskog. (2010). University of Pennsylvania Press. Buddhism and Islam. On the Silk Road.
13. https://en.wikipedia.org/wiki/List_of_countries_and_dependencies_by_population ,
https://en.wikipedia.org/wiki/List_of_countries_and_dependencies_by_area,
<https://www.worldometers.info/world-population>